**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 17 өдөр Дугаар А/61 Онги

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Найз багийн нутаг "Их өндөр" гэх газар нутаглаж буй малчин Б.Шинэбаярын суурьт бог малын мялзан өвчний шинж тэмдэг бүдгэрч эдгэрсэнтэй холбогдуулан 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 17-ны өдрийг дуустал 14 хоногийн хугацаанд тогтоосон хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Хязгаарлалтын дэглэм цуцлагдсан ч малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч, Найз багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ард иргэд, малчдыг малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улмын байцаагч (Ц.Саранчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.ЛУВСАНРАГВА